

ХЭНД, ЯАЖ, ЯМАР АРГААР

I байр
Ж.Энхжаргал, оюутан
МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль,
философийн 4-р анги

*Хэн ч таныг харахгүй байгаа юм шиг бүжиглэ
Хэн ч сонсохгүй байгаа юм шиг чангаар дуул
Хэзээ ч шаналж байгаагүй юм шиг хайрлан дуул
Хэдийгээр дэлхий диваажин биш ч, диваажин юм шиг амьдар!*

1981 оны тэр нэгэн гунигтайхан өдөр хүн төрөлхтөнийг цочроосон нэгэн аймшигт үйл харанга дэлдсээр бидний дунд шургалан оржээ. Тиймээ, энэ бол нөгөөх бүрэн төгс эмчлэгддэггүй, гарсан цагаасаа хойш 37.8 сая хүний амийг авч дэлхий дээрх нас баралтын 4 дэх шалтгаан болоод байгаа AIDS/ДОХ юм. Гэхдээ аюул дэгдээсэн энэхүү өвчин хэдийгээр бүрэн төгс эмчлэгддэггүй боловч шувууны ханиад, SARS шиг амьсгалын замаар халдвар тараахгүй, гагцхүү өөрөө өөртөө дээд зэргийн сонор сэрэмж, анхаарал тавьж чадвал уг өвчнөөр халдварлана гэж айлтгүй ээ.

Анхаарал Тавь!. Тохиолдлын бэлгийн хавьталд орохгүй байх, зүү тариур зэрэгтэй болгоомжтой харьцаж аль болох ил шарх авахгүй байх, тохиолдлын бэлгийн харьцаанд орохгүй байх. Та зөвхөн эдгээрийг л тэвчиж чадвал танд ДОХ халдахгүй. Харин ДОХ-ын нэгэн аймшигт үнэн нь тэрээр эхийн сүүгээр, эхээс хүүхдэд халдах, аюул бий.

Хэдийгээр хүн болгон дээрхийг мэддэг ч ДОХ-ын нян тээгч, эсвэл ДОХ-оор өвчилсөн хүнтэй нэг л их аюултай, бушуухан л хажуугаас нь холдож цэрвэхгүй бол яг л ДОХ-той болох нь гэсэн байдлаар ханддаг нь тэдэнд ингэж амьдрахаар шуудхан л гэсэн бодол төрүүлчихдэг.

“6 жилийн өмнөх тэр нэгэн намрын жижүүн өдөр Хүний Дархлал Хомсдолын Вирусын халдвартай буюу ДОХ өвчний тээгч вирус гэдгийг мэдсэн тэр хар өдрийг би хэзээ ч мартаж чадахгүй”, “... мэдээж би халдвартай болсноо мэдээд ямар их гутарсныг минь хэлээд баригүй”, “... би амиа хорлоё гэж бодож байлаа.”

“Би ойлгодоггүй. Яагаад ДОХ-ын халдвартай хүмүүсийг ялгаварлан гадуурхаж, элдвээр бичиж байдаг юм бэ? Хүмүүс миний тухай ямар ч бодолтой байлаа гэсэн тэднийг өөрийгөө өвчнөөс хамгаалах мэдлэгтэй чадвартай байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсч байна. Ертөнцийн төгсгөл болоогүй байна. Би ингэж бодох эрхтэй хүн билээ” /www.dotno.mn/

Хүний Дархлал Хомсдолын Вирус тээгч хүнийг бид ялгаварлан гадуурхаж жигшсэнээр өнөөдөр дэлхий ДОХ хэмээгч өвчингүй болчихгүй. Харин түүний талаарх мэдээ, мэдээллийг хүртээмжтэй байдлаар олон нийтэд ялангуяа эмэгтэйчүүдэд, хүүхэд залуучуудад энэ талын мэдлэгийг тэдний онцлогт тохируулан зөв зүйтэй арга замаар өгөх нь чухал юм. Учир нь дэлхий дээрх нийт ДОХ-ын нян тээгч 37.8 сая хүний 30 гаруй хувь нь 25-аас доош насны хүмүүс

бөгөөд эдгээрийн 2/3-ыг нь эмэгтэйчүүд эзэлж, 15-24 насны 12 сая хүүхэд, залуучууд ХДХВ-гийн халдвартай амьдарч байгаа бөгөөд өдөрт 6000 залуучууд шинээр ХДХВ-гийн халдвар авч байна. Энэ бүгдээс үзэхэд уг өвчний эсрэг тэмцэхдээ хэнд хандсан үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй болох нь ойлгомжтой боллоо. ДОХ-ын талаарх хүмүүст ойлгогддог буруу мэдээллийг залруулах үүднээс хэвлэл мэдээлийн хэрэгсэл ашиглан олон түмний сэтгэл зүйд хандсан нэвтрүүлгүүдийг зөвхөн дэлхий нийтээр ДОХ-той тэмцэх 12 сарын 1-ний өдөр явуулах бус улирал, сар болгон үүнтэй холбоотой мэдээллийг олон түмэнд хүртээмжтэй байдлаар тархааж, ойлгуулах хэрэгтэй байна. Мөн бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилөх эрсдэл бүх биеэ үнэлэгч хүмүүст бэлгийн замын халдварт өвчин хийгээд түүнээс үүдэх хор хохирол ДОХ-ын тухай мэдээллийг өгдөг ИТГЭЛ төслийн хугацаа дуусах тохиолдолд цааш үргэлжлүүлэн, 10 жилийнхний дунд гэр бүл хичээлийг ДОХ-той тэмцэх өдөртэй холбогдуулан зохиочоод орхих биш цаашид үргэлжлүүлэх шаардлагатай байна.